



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймгийн Улаангом, Түргэн, Бөхмөрөн, Наранбулаг сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд болсон 4 нэрийн нийт 1,166,019,963.00 (нэг тэрбум нэг зуун жаран зургаан сая арван есөн мянга есөн зуун жаран гурван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

132001200

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 28 дугаар сарын 29-ний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

**"УВС ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал	Нийт үнэ (төгрөг)	Байршил
1	0.4 кВ, 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл	10 кВ-ын ЦДАШ, 0.4 кВ-ын ЦДАШ, 0.4 кВ-ын тоолуур	269,371,851.00	Увс аймаг Улаангом сум, 12-р баг
2	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	0.4 кВ-ын ЦДАШ, 10/04 кВ-ын 160 кВа АТП-ын шинэчлэл	197,489,259.00	Увс аймаг Түргэн сум
3	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	0.4-10 кВ, 100-250 кВа	599,428,447.00	Увс аймаг Бөхмөрөн сум
4	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, шинэчлэл	10/0.4 кВ-ын АТП шинэчлэх, 0.4 кВ-ын 3 км ЦДАШ, 60 тоолуур	99,730,406.00	Увс аймаг Наранбулаг сум
Нийт дүн			1,166,019,963.00 (нэг тэрбум нэг зуун жаран зургаан сая арван есөн мянга есөн зуун жаран гурван төгрөг)	-